



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/109

Мандалговь

Уул уурхайн бүтээгдэхүүн, ашигт малтмал  
тээвэрлэх авто замд хяналт хийх  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэр дээгүүр дайран өнгөрч буй улсын болон орон нутгийн чанартай замаар уул уурхайн бүтээгдэхүүн, ашигт малтмал тээвэрлэх аж ахуйн нэгжүүдэд хяналтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Л.Баярсайхан	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
Гишүүд:	Б.Мөнхбат	(Аймгийн Цагдаагийн газрын дарга)
	Н.Гантулга	(Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
	Ц.Хүрэлбаатар	(Аймгийн Автотээврийн төвийн дарга)
	Н.Батболд	(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Авто тээвэр өргөх механизмын хяналтын Улсын байцаагч)
Нарийн бичгийн дарга:	Б.Бум-Очир	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, эрдэс баялаг, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн)

2. Уул уурхайн бүтээгдэхүүн, ашигт малтмал тээвэрлэлт хийх улсын болон орон нутгийн чанартай авто замын маршрутаар тээвэрлэлт хийж буй аж ахуйн нэгжүүдийн тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт хийн танилцуулахыг ажлын хэсэг (Л.Баярсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100246